

**“ӨНДӨРХААН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

24/03

Огноо: 2024 оны 8 сарын 21

Цаг: 15:00

Хурал хуралдуулах газар /хаяг, байршил/: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхарт

Хурал зарлагч: Төлөөлөн Удирдах Зөвлөл

Хурлын дарга: Ө.Ашхүү

Хуралд оролцсон: Хурал зохион байгуулах комисс, Хурлын дарга, Хувьцаа эзэмшигчид, Тооллогын комиссын бүрэлдэхүүн

“Өндөрхаан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг энэхүү хурлын дэгийн дагуу 15:00 цагт нээв.

ХУРЛЫГ НЭЭСЭН НЬ:

Ө.Ашхүү: Өдрийн мэнд, Өнөөдрийн хурлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 24/08 дугаартай тогтоолын дагуу Хурлын даргаар Ө.Ашхүү би даргална. Иймд та бүхэнд өнөөдрийн хурлын дэгийг танилцуулъя. *(хурлын дэгийг танилцуулав.)* За ингээд хурлын дэгийн дагуу 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хурлын ирцийн талаар мэдээлэхийг тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хүсэж байна.

Тооллогын комисс: Өнөөдрийн “Өндөрхаан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн тухай танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй нийт 111,879 ширхэг хувьцаанаас 62,812 ширхэг буюу 56.14 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал №1 Өндөрхаан ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр томилох.

М.Мөнхбадрал: Компанийн одоогийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийн ердийн гишүүд болох Г.Цогбадрах, Г.Сэлэнгэ, Ч.Хандсүрэн, Г.Уянга, Ө.Ашхүү, С.Дэлгэржаргал нар болон хараат бус гишүүд буюу Ц.Батбаяр, Д.Батбаяр, П.Халиун нарын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, шинээр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчид дэвшиж буй тухай холбогдох танилцуулгыг хувьцаа эзэмшигч нарт танилцуулав.

Ердийн гишүүд:

1 Ч.Ганхуяг

- 2 Н.Эрдэнэтулга
- 3 Б.Золбоо
- 4 Ц.Тайшир
- 5 С.Нямгэрэл
- 6 Г.Билгүүн

Хараат бус гишүүд:

- 7 А.Азбаяр
- 8 Б.Солонго
- 9 О.Одсайхан

Хэлэлцэх асуудал №2 Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

М.Мөнхбадрал: Компани нь Дүрэмдээ дараах шинэчлэлтийг хийж байгаа болно. Компанийн Дүрмийн 1.8 дахь хэсэгт “Компани нь Хүчтэй. Хамтдаа. гэсэн уриа үгтэй байна” , 1.9 дэх хэсэгт “Компани нь хоронго оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнуудаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй” 4.1 дэх хэсэгт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй ... ширхэг энгийн зарласан хувьцаатай байна” гэж нэмэлтээр оруулахаар байна.

Хэлэлцэх асуудал №3 Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай.

М.Мөнхбадрал: Компани нь хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргаж, Компани болон Ард Санхүүгийн Нэгдэл ХК нарын хооронд байгуулсан Санхүүжилтийн гэрээний холбогдох заалтын дагуу 15,000,000,000 төгрөгийн өрийг хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэх тухай төслийг танилцуулж, хэлэлцэв.

АСУУЛТ, ХАРИУЛТ:

Байхгүй.

САНАЛ ХУРААЛТ:

Тооллолын комисс:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, шинээр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай асуудлаар нийт саналын эрхтэй 62,812 ширхэг буюу 56.14 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 62,812 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

- 1.1. Зөвшөөрсөн: 62,812 Ширхэг буюу 100 %

Татгалзсан: 0 Ширхэг буюу 0%

Түдгэлзсэн: 0 Ширхэг буюу 0%

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

1.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

1.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 62,812 ширхэг буюу 56.14 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 62,812 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

2.1. Зөвшөөрсөн: 62,812 Ширхэг буюу 100 %

Татгалзсан: 0 Ширхэг буюу 0 %

Түдгэлзсэн: 0 Ширхэг буюу 0 %

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100 %

2.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

2.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

3. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 62,812 ширхэг буюу 56.14 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 62,812 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

3.1. Зөвшөөрсөн: 0 Ширхэг буюу 0 %

Татгалзсан: 0 Ширхэг буюу 0 %

Түдгэлзсэн: 62,812 Ширхэг буюу 100 %

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100 %

3.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

3.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

Ө.Ашхүү: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, шинээр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох;

2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

3. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах эсэх тухай асуудлыг тус тус хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг үндсэлэн хэлэлцэн батлав.

ХУРЛЫН ХААЛТ:

Ө.Ашхүү: Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хурал хаалаа.

Хянасан,

Хурлын дарга Ө.Ашхүү

Тэмдэглэл хөтөлсөн,

М.Мөнхбадрал:



М. Мөнхбадрал